

Хямдрал

“Жирэлзээ” цахилгаан тээврийн компани шинэ төрлийн нийтийн тээврийн үйлчилгээ гаргажээ. Троллейбусны билетийн үнэ өдөр бүр өөр өөр байж болох ба 100-гаас дээш төгрөгний билет авч зорчсон тохиолдолд нэг удаа автобусаар үнэгүй үйлчлэх эрхээр шагнана (100 төгрөгний эсвэл түүнээс бага үнэтэй билет авсан зорчигчид ийм эрх өгөхгүй).

Оюутан Билгүүн ойрын N өдрийн билетийн үнийн жагсаалтыг олж аваад эдгээр өдөр бүр нэг удаа троллейбусаар зорчихоор шийдсэн. Билгүүний стипенд ердөө л 70 мянган төгрөг тул нийт зардлыг хамгийн бага байлгахын тулд зарлагдсан хямдралыг хамгийн ашигтайгаар хэрэглэхийг хичээж байгаа.

Эдгээр N өдөрт Билгүүний гаргах нийт зардлын боломжит хамгийн бага утгыг ол.

Input

Оролтын файлын эхний мөрөнд N бүхэл тоо байрлана ($0 \leq N \leq 100$). Дараагийн N тооны мөр бүрт харгалзах өдрийн билетийн үнэ болох бүхэл тоо байрлана. Билетийн үнэ нь 300-гаас хэтрэхгүй, сөрөг биш бүхэл тоо байна.

Output

Нийт зардлын боломжит хамгийн бага утгыг хэвлэнэ.

Example

Input:

5

35

40

101

59

63

Output:

235